



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/594

Есөнбулаг

Бугат сумын Тахийн талын бага сургуулийн орчны тохижилтын ажилд дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 39 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн 3.5.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Бугат сумын Тахийн талын бага сургуулийн орчны тохижилт хийх зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс Э.(Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР